



“ЗООС ГОЁЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС I ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 08 дугаар сарын 24-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

*Хувьцааг нэгтгэх үйл ажиллагааг
хэрэгжүүлэх тухай*

Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1, 51.2, 51.4, 51.5, 55 дугаар зүйлийн 55.8, 55.9 дахь заалтуудыг удирдлага болгон Хөндлөнгийн хараат бус үнэлгээний байгууллагын тайлан, дүгнэлт, “Зоос Гоёл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2013 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит бус I-р хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Зоос Гоёл” ХК-ийн хувьцааг нэгтгэх төслийг хавсралтаар баталсугай.
2. Төсөл хэрэгжүүлэх үндсэн үзүүлэлтүүдийг доорхи байдлаар тогтоосугай.
Үүнд:
 - 2.1 “Зоос Гоёл” хувьцаат компанийн 288 ширхэг энгийн хувьцааг 1 шинэ энгийн хувьцаанд хөрвүүлэх замаар нэгтгэх,
 - 2.2 Хувьцааг нэгтгэсний дараа 55 ширхэг буюу түүнээс дээш тооны бутархай хувьцаатай үлдэж буй хувьцаа эзэмшигчдэд нэгтгэсэн дүнд хүрээгүй хувьцааг худалдан авах эрхийг эдлүүлэх,
 - 2.3 Компани хувьцааг нэгтгэсний үр дүнд бий болсон хувьцааны бутархай үлдэгдлийг хувьцаа эзэмшигчдээс эргүүлэн худалдан авах, эрх үүссэн хувьцаа эзэмшигчид бутархай хувьцаагаа нэгтгэсэн дүнд хүргэхэд шаардлагатай хувьцааг компаниас худалдан авах журмыг хэрэгжүүлэх нэгж хувьцааны үнийг 720 /долоон зуун хорь/ төгрөгөөр тогтоох.
3. Нэгтгэсний үр дүнд бий болох бутархай хувьцааг худалдан авах, эргүүлэн худалдах эрхийг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.
4. Хорооноос хувьцааг нэгтгэх асуудлыг зөвшөөрсөн шийдвэр гарсан тохиолдолд “Компанийн хувьцааг нэгтгэх төсөл”-ийг хэрэгжүүлэхийг ТУЗ-д даалгасугай.



ХУРЛЫН ДАРГА

Ж. Билэгт

Ж. БИЛЭГТ

2013 оны 8-р сарын 24-ны өдрийн Хувьцаа
эзэмшигчдийн ээлжит бус нэгдүгээр
хурлын 01 тоот тогтоолоор батлав.

“ЗООС ГОЁЛ” ХК-ИЙН ХУВЬЦААГ НЭГТГЭХ ТӨСӨЛ

НЭГ. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү “ЗООС ГОЁЛ” ХК-ИЙН ХУВЬЦААГ НЭГТГЭХ ТӨСӨЛ /цаашид “Төсөл” гэх/ нь “Зоос гоёл” ХК-ийн хувьцааг компанийн тухай хуульд заасны дагуу нэгтгэх шийдвэр гаргах, нэгтгэх ажиллагааг хэрэгжүүлэх, хувьцааг нэгтгэсэнтэй холбогдон үүсэх хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх, компанийн хувьцааны бүртгэл, үнэт цаасны бүрдүүлбэрт болон дүрэмд зохих өөрчлөлт оруулах, хувьцааны бүртгэл орсон өөрчлөлтийг ҮЦТТХТ-д, дүрэмд орсон өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдсон ажиллагааг зохицуулахад чиглэгднэ.
- 1.2 Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд Хувьцаат компани нь эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр 2 буюу түүнээс дээш /нийт гаргасан энгийн хувьцааны 1 хүртэлх хувьтай тэнцэх/ тооны хувьцааг тухайн төрлийн нэг шинэ хувьцаанд хөрвүүлэх замаар нэгтгэж болох талаар заасан нь компанийн хувьцааг нэгтгэх эрх зүйн үндэс болно.
- 1.3 Төслийн гол онцлог нь түүнийг хэрэгжүүлснээр хувьцаа эзэмшигчдийн тэр дундаа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөхгүй байх тал дээр анхаарлаа голлон хандуулсанд оршино.

ХОЁР. Компанийн хувьцааг нэгтгэх шалтгаан, зорилго, ач холбогдол

- 2.1 Компани нь хувьцааны тархалт ихтэй, олон хувьцаа эзэмшигчтэй боловч жижиг хувьцаа эзэмшигчийн /ЖХЭ/ тоо харьцангуй их тухайлбал 2013 оны 7 дугаар сарын 9-ны бүртгэлийн өдрийн байдлаар нийт 11,441 хувьцаа эзэмшигчийн ердөө 0,15 хувь буюу 17 хувьцаа эзэмшигч нь нийт хувьцааны 0.1% болох 3,700 ширхэгээс дээш хувьцаатай, дийлэнх олон нь буюу 99.85% болох 11,424 хувьцаа эзэмшигч нь 1-2,160 ширхэг хувьцаатай тэдний нийт эзэмшиж буй хувьцааг ХЭ-ийн тоонд хуваахад нэг хувьцаа эзэмшигч дунджаар 88 ширхэг хувьцаатай байна. Эдгээр ЖХЭ-дийн дийлэнх нь 1990-ээд оны дундуур өмч хувьчлалын цэнхэр тасалбараараа /улсын захиалгаар мөнгөн тэмдэгт, одон медаль хийдэг, мөн алт үнэт эдлэл үйлдвэрлэдэг тухайн чиглэлээр улсын монополь үйлдвэр байсан/ тус компанийн 50-60 ширхэг хувьцаа авсан байдаг. Гэвч улс орон маань зах зээлийн нийгэмд шилжсэнээр олон үйлдвэрийн газрууд хаалгаа барин дампуурахтай хамт манай компанийн хувьд ч хүнд үе эхлэн /хувьд шилжүүлснээс хойш улсын захиалга хумигдсан, үйлдвэрийн гол түүхий эд алт, мөнгөний үнэ өссөн, техник тоног төхөөрөмжүүд хуучран элэгдэн хоцрогдолд орсноос бүтээгдхүүний өртөг улам нэмэгдсэн, гаднаас орц, өртөг багатай хямд бүтээгдхүүн чөлөөтэй орж ирэх болсон, иргэдийн худалдан авах чадвар муудсан зэрэг олон шалтгааны улмаас/ тасралтгүй ажиллаж ирсэн ч үйлдвэрлэлийн ашиг төдийлөн нэмэгдэхгүйн улмаас ашиг багатай, зарим жил алдагдалтай ажиллах болсон байна. Харин 2003 оноос үйлдвэрлэлийг шат дараатайгаар зогсоон үйлдвэрийн байраа засаж конторын зориулалтаар түрээслүүлж эхэлснээр ашиг жил дараалан нэмэгдэх болсон бөгөөд сүүлийн 3 жилийн дундаж ашиг 130,0 сая төгрөг, нэгж хувьцаанд дунджаар /2010-2011 онуудад/ 14,0 төгрөгийн ногдол ашигт хуваарилснаас харахад дийлэнх олон

- болох 11,500 орчим ЖХЭ-дэд ногдох нь жилд дунджаар 15,0 сая төгрөг, 1 хүнд 1,300 төгрөг оногдож байгаа нь үнэхээр бага, орлого 2-3 дахин нэмэгдлээ ч бас хангалтгүй байхаар байна. Гэвч түрээсийн байр талбайн хэмжээ, үнэ хязгаартай тул бидний орлого өнөөгийн байдлаар /томоохон хөрөнгө оруулалт хийсэн төсөл хэрэгжүүлээгүй тохиолдолд/ огцом өсөх боломж бололцоо тааруу түрээсийн талбайн үнийн өсөлтөөр л зохицуулагдах учраас ногдол ашгийн хэмжээ ч мөн энэ хэмжээгээр багахан хувиар өсөх боломжтой. Хувьцаа эзэмшигчдийн ихэнх нь хувьцаа эзэмшигчдийн хуралдаа ирдэггүй, 70-аад хувь нь ногдол ашгаа ч огт ирж аваагүй байна. 2011-2013 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлуудад нийт 7-9 хувьцаа эзэмшигчид хуралдаа оролцсон нь нийт хувьцаа эзэмшигчдийн ердөө л 0,06-0,08 хувь байсан. Мөн 2011 оны ногдол ашиг тарааснаас хойш 1 жил 4 сарын хугацаанд /томоохон 10-аад хувьцаа эзэмшигчдийг эс тооцвол/ нийт 189 хувьцаа эзэмшигч ирж ногдол ашгаа авсан байгаа нь ердөө л нийт хувьцаа эзэмшигчийн 1,6 хувь, ногдол ашгийн дүнгийн 3,7 хувь болж байна. Хувьцаа эзэмшигчдийн эдгээр идэвхигүй, хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхгүй байгаа байдал, ирсэн цөөн ХЭ-д нь /нэг талын таксины төлбөрт ч хүрэхгүй мөнгө өглөө гэх...хувьцаагаа эргүүлэн ав гэх мэтээр.../ уурлан бухимдаж, загнаж зандрах нь бидэнд үйл ажиллагаагаа явуулахад хүндрэлтэй байхаас гадна компанийн хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэхтэй холбогдсон зардал, ногдол ашгийн өглөгийг жил бүрээр нэмэгдүүлж санхүүгийн тайлангийн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлөх зэргээр тодорхой хэмжээний бэрхшээл учруулж ирсэн. ЖХЭ-дийн хувьд ч мөн ялгаагүй өмч эзэмших, ахиу ашиг хүртэх хүсэл зорилго, эрх нь хөндөгдөж байгааг дурьдах нь зүйтэй. Сүүлийн жилүүдэд ирж буй хувьцаа эзэмшигчдийн ихэнх нь хувьцаагаа зарах хүсэлтэй боловч яаж зарахаа мэдэхгүй, ҮЦ-ны арилжааны талаар ойлголтгүй байна. Ийнхүү дээр дурдсан компани болон хувьцаа эзэмшигчдэд тохиолдож буй бэрхшээл, нөхцөл байдлууд нь хувьцааг нэгтгэх хангалттай шалтгаан төдийгүй цаг үеэ олсон шийдвэр гэж компанийн Төлөөлөн удирдах зөвлөл үзэж байна.
- 2.2 Хувьцааг нэгтгэх нь компанийн хувьцааны арилжааг идэвхижүүлэх, нэмж хувьцаа гарган хөрөнгө оруулалт татах, ингэснээр хэт төвлөрлийг задлан арилжааг зах зээлийн гольдролд нь оруулах, хувьцааны нэрлэсэн үнэ өсөх, үүний үр дүнд зах зээлийн үнийн хий хөөрөгдөл буурч хувьцааны зах зээл дээрх үнэ ханш, дүрмээрх нэрлэсэн үнэ, нэгж хувьцаанд ногдох тайлан балансаарх өөрийн хөрөнгийн дүнгийн хоорондох зөрүү багасах, ашиг нэмэгдэн, өглөг буурснаар санхүүгийн үзүүлэлтийг дээшлүүлэх, идэвхигүй жижиг хувьцаа эзэмшигчдийн тоог бууруулах, зарим идэвхитэй хэсэгт нь учирдаг байсан багахан мөнгөний төлөө жил бүр хол ойроос ирэх зардал чирэгдэл, бухимдал арилах, ЖХЭ-дийн эзэмших хувьцааны тоо, хувь өсөх зэрэг олон талын зорилго, ач холбогдлыг агуулж байгаа билээ.
- 2.3 Энэхүү төсөл хэрэгжигдэн бутархай хувьцаагаа компанид эргүүлэн батлагдсан үнэ болох 720 төгрөгөөр худалдсанаар нэгж хувьцаанаас өнөөдрийн авч буй ногдол ашгаар тооцоход $(720:18=40)$ 40 жил авах ногдол ашгийн дүнтэй тэнцэхээр байна. Хэдийгээр дээрхи үнэ нь хувьцааны зах зээлийн үнэ ханш гэх биржийн арилжааны ханшаас /2013.03.05-ны байдлаар сүүлийн 52 долоо хоногийн жигнэсэн дундаж 981 төгрөг байсан/ бага байгаа ч компанийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн цэвэр өөрийн хөрөнгийн нэгж хувьцаанд ногдох 428,8 төгрөгтэй харьцуулахад 291,2 төгрөгөөр, хараат бус үнэлгээний байгууллагаас компанийн нийт хөрөнгөнд хийсэн дахин үнэлгээний өөрчлөлтийг тусгасан нийт өөрийн цэвэр хөрөнгийн нэгж хувьцаанд ногдох дүн 544,5 төгрөгтэй харьцуулахад 175,5 төгрөгөөр тус тус их байгаа юм.

**ГУРАВ. Төслийн агуулга, үндсэн үзүүлэлтүүд,
зарим нэр, томъёоллын тайлбар**

- 3.1 Хувьцааг нэгтгэснээр компанийн нийт гаргасан 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3,754,944 ширхэг энгийн хувьцааг 288 ширхэгээр нэгтгэн нэг шинэ энгийн хувьцаа /цаашид “шинэ хувьцаа” гэх/ -нд хөрвүүлэх, ингэснээр компани 28,800 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 13,038 ширхэг шинэ хувьцаатай болно.
- 3.2 Компанийн хувьцаа эзэмшигч бүрийн эзэмшиж буй хувьцаа нь мөн адил аргаар хөрвүүлэгдэнэ.
- 3.3 ХЭХ-ын шийдвэр гарсан өдрөөр хувьцааны арилжааг түр зогсоолгон, тухайн өдрөөр төсөл хэрэгжүүлэх бүртгэлийн өдрийг тогтооно.
- 3.4 Компани нэгтгэсний үр дүнд бий болсон бутархай үлдэгдлийг /цаашид “бутархай хувьцаа” гэх/ хувьцаа эзэмшигчдээс эргүүлэн худалдан авах үүрэг хүлээнэ.
- 3.5 Харин 55 ширхэг буюу түүнээс дээш бутархай үлдэгдэлтэй хувьцаа эзэмшигч нэгтгэсэн дүнд хүргэхэд шаардлагатай хувьцааг компаниас эргүүлэн худалдан авах эрх эдэлнэ.
- 3.6 Дээрх эрх, үүргийг хэрэгжүүлэх нэгж хувьцааны үнийг Компанийн тухай хуулийн 51.4-т заасны дагуу компанийн төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ хөндлөнгийн, хараат бус үнэлгээний байгууллагын хийсэн тус компанийн хөрөнгийн болон бизнес үнэлгээний тайланд үндэслэн, мөн нэгтгэсний үр дүнд бий болсон бутархай бүх үлдэгдлийг хувьцаа эзэмшигчдэд нэгтгэсэн дүнд хүргэхэд шаардлагатай хувьцааг уг үнээр эргүүлэн худалдахаар санал болгож буйг харгалзан 720 төгрөгөөр тогтоон /цаашид “тогтоосон үнэ” гэх/ хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан.
- 3.7 55 ширхэгээс доош бутархай үлдэгдэлтэй хувьцаа эзэмшигчдэд хувьцаа худалдан авах эрх үүсэхгүй бөгөөд бутархай үлдэгдлийг тогтоосон үнээр компани худалдан авна.
- 3.8 Хувьцаа эзэмшигч нэгтгэсэн дүнд хүргэхэд шаардлагатай хувьцааг /1-233 ширхэг/ компаниас эргүүлэн худалдан авах эрхээ хэрэгжүүлэх хугацаа нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны хувьцааг нэгтгэхийг зөвшөөрсөн шийдвэр гарсан өдрөөс хойш календарийн 45 хоног /цаашид “зарласан хугацаа” гэх/ байна.
- 3.9 “Төсөл хэрэгжих хугацаа” гэдгийг Хорооны хувьцааг нэгтгэхийг зөвшөөрсөн шийдвэр гарсан өдрөөс эхлэн төсөл бүрэн хэрэгжиж, компанийн хувьцааны бүртгэл, үнэт цаасны бүрдүүлбэр, дүрэмд орсон өөрчлөлтүүдийг холбогдох дээд шатны байгууллагуудад зохих журмын дагуу бүртгүүлснээр дуусах хугацааг хэлнэ.
- 3.10 Компанийн хувьцааг нэгтгэх үйл ажиллагааг ТУЗ-өөс томилогдсон комисс /цаашид “комисс” гэх/ эрхлэн гүйцэтгэнэ.
- 3.11 Комисс нь хувьцааг нэгтгэх асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурал /ХЭХ/-аар хэлэлцэн баталснаар Хороонд хүргүүлэн зохих зөвшөөрөл, шийдвэрийг гаргуулах, Хорооны шийдвэр гаран төсөл хэрэгжиж дуустал хувьцааны арилжааг түр зогсоолгуулах арга хэмжээг авах, бүртгэлийн өдрөөрх хувьцаа эзэмшигчдийн бүртгэл, судалгаанд үндэслэн төслийн тооцоо, судалгааг дэлгэрэнгүйгээр гаргах, хувьцаа худалдан авах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдэд тухайн эрх үүссэн тухай, түүнийгээ хэрэгжүүлэх журмын талаарх мэдээллийг хүргэх, эрхээ хэрэгжүүлэх хүсэлт гаргасан ХЭ-дийн хүсэлтийг хянан хүлээн авч баталгаажуулах, зарласан хугацаа дууссанаар төслийн нэгтгэсэн тайланг харьяалах дээд байгууллагуудад хүргүүлэн хянуулж, компанийн хувьцааны бүртгэл болон дүрэмд зохих өөрчлөлтийг оруулах зэрэг төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. Компанийн хувьцааг нэгтгэсний үр дүнд бий болсон хувьцааны бутархай үлдэгдлийг компани эргүүлэн худалдан авах, Хувьцаа эзэмшигчид бутархай хувьцаагаа нэгтгэсэн дүнд хүргэхэд шаардлагатай хувьцааг компаниас худалдан авах журам

- 4.1 Энэхүү журмын зорилго нь компанийн хувьцааг нэгтгэсний үр дүнд бий болсон хувьцааны бутархай үлдэгдлийг компани эргүүлэн худалдан авах үүргийг хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигч бутархай хувьцаагаа нэгтгэж буй дүнд хүргэхэд шаардлагатай хувьцааг компаниас худалдан авах эрхээ хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, тэдгээрийн бүртгэлийг хөтлөн баталгаажуулах үйл ажиллагааг дэлгэрэнгүй тайлбарлан хүргэхэд оршино.
- 4.2 Хорооны хувьцааг нэгтгэхийг зөвшөөрсөн шийдвэр гармагц энэ төслийн 3.5-д заасан хувьцаа эзэмшигчид нэгтгэсэн дүнд хүргэхэд шаардлагатай хувьцааг нэмж компаниас худалдан авах эрх үүсэх бөгөөд уг эрхээ хэрэгжүүлэх “Хүсэлтээ” энэ төслийн 3.8-д заасан зарласан хугацааны дотор компани /төсөл хэрэгжүүлэх комисс/-д гаргана.
- 4.3 Уг “Хүсэлт”-д дараахь зүйлс /бичиг баримтууд/ заавал байх шаардлагатай.
Үүнд:
- 4.3.1 Бичгээр гаргасан өргөдөл, хүсэлт /ХЭ-ийн Өөрийн (нэр, РД, холбоо барих хаяг, утас) болон Хувьцааны (эзэмшигч байгаа хувьцааны тоо, БДК-ийн нэр, ҮЦ-ны дансны дугаар) мэдээлэл, Нэгтгэсэн дүнд хүргэхэд шаардлагатай байгаа ширхэг хувьцааг худалдан авахыг хүсэж байгаагаа бичиж гарын үсэг зурж баталгаажуулсан байна/,
- 4.3.2 ХЭ-ийн иргэний үнэмлэхийн хуулбар, ААНБ-ын хувьд гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан/,
- 4.3.3 Худалдан авах хувьцааны төлбөрийг /энэ төслийн 3.6-д заасан тогтоосон үнээр тооцож/ Компанийн дансанд тушаасан баримтын хуулбар.
- 4.4 Хувьцаа эзэмшигч “Хүсэлт”-ээ “Зоос Гоёл” ХК дээр байрлах комисст өөрийн биеэр болон төлөөний хүнээр хүргүүлэх боломжтой.
- 4.5 Мөн хөдөө орон нутгийн ХЭ-д өөрийн БДК-аараа дамжуулан “Хүсэлт”-ээ ирүүлж болно. Тухайн нөхцөлд таны Хүсэлтийг БДК-ийн хүлээн авсан хугацаагаар бус харин БДК-аас “Зоос Гоёл” ХК-ийн Төсөл хэрэгжүүлэх комисст төслийн 4.3-д заасан шаардлагыг хангасан материал ирүүлсэн хугацаагаар тооцохыг анхаарна уу.
- 4.6 Комисс “Хүсэлт”-ийг хүлээн авч өөрийн жагсаалт, баримттай тулган хянаад бүрэн, зөв тохиолдолд хүлээн авч, хүлээн авсныг нотлох баримт олгоно. Төсөл хэрэгжиж дуустал уг баримтаа хадгалах хэрэгтэй.
- 4.7 Хувьцаа нэмж худалдан авах эрх үүссэн хэдий ч зарласан хугацаанд компанид “Хүсэлт”-ээ гаргаагүй компанид худалдахыг зөвшөөрсөнд тооцох бутархай хувьцааг энэ төслийн 3.4-д заасны дагуу компани эргүүлэн худалдан авна.
- 4.8 Энэ төслийн 3.5-д заасан эрх үүссэн ХЭ-дэд энэ талаарх /хувьцаа худалдан авахаар үүссэн тухай болон эрхээ хэрэгжүүлэх журмын/ мэдээллийг хүргэхдээ “ХЭХ-ийн зар хүргэх тухай” КТХ-ийн 65-р зүйлийн 65.1, 65.4 дахь заалт, мөн Хорооноос гаргасан тус журмын зар, мэдээлэл хүргэхтэй холбогдсон зүйл заалтыг баримтлана.
- 4.9 Зард дараахь мэдээллүүдийг тусгана.
Үүнд:
- 4.9.1 Компанийн нэр, байршил, зарын агуулга,
- 4.9.2 Эрх үүссэн ХЭ хувьцаа худалдан авах эрхээ хэрэгжүүлэхээр “Хүсэлт”-ээ компанид гаргах хугацаа, хүлээн авах сүүлийн хугацаа, газар- /төслийн 3.8-д заасан зарласан хугацааг ойлгоно/,
- 4.9.3 Уг “Хүсэлт”-ийг гаргахад бүрдүүлэх бичиг, баримтуудын жагсаалт,

- 4.9.4 Эрх үүссэн ХЭ-дийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр-/энэ төслийн 3.3-д заасан төсөл хэрэгжүүлэх бүртгэлийн өдөр буюу ХЭХ-ийн шийдвэр гарсан өдрийг ойлгоно/,
- 4.9.5 Дансны мэдээлэл -/хувьцаа эзэмшигчид компаниас худалдан авч буй нэгтгэсэн дүнд хүргэхэд шаардлагатай хувьцааны төлбөр хийх банкны түр данс/,
- 4.9.6 Төсөл хэрэгжүүлэх комиссын ажиллах цагийн хувиар, холбоо барих утас, электрон шуудангийн хаяг,
- 4.9.7 Уг асуудалтай холбоотой танилцах материалын жагсаалт
- 4.9.8 Бусад шаардлагатай мэдээлэл
- 4.10 Комисс нь ХЭ-дэд хүртээмжтэй мэдээлэх үүргийг хариуцах, шаардлагатай тохиолдолд Хөрөнгийн бирж, түүний БДК-уудыг татан оролцуулах замаар тэдгээрийн туслалцаа дэмжлэгийг авах арга хэмжээ авна.
- 4.11 Компани Хорооны шийдвэр гармагц бүртгэлийн өдрөөрх ХЭ-дийн бүртгэлд тулгуурлан тооцсон нийт бутархай хувьцааны төлбөрийн 50-иас доошгүй хувьтай тэнцэх дүнг ҮЦТТХТ-ийн дансанд буюу Компанийн нэр дээрх зориулалтын түр дансанд /зөвшилцсөний үндсэн дээр/ урьдчилгаа баталгаа болгон байрлуулна.
- 4.12 Харин зарласан хугацаа дуусмагц Хүсэлт ирүүлсэн ХЭ-дийн компанийн түр дансанд тушаасан төлбөр тооцоог банкны хуулга, баримтанд үндэслэн хувьцаа нэмж худалдан авсан ХЭ-дийн нэрсийн жагсаалтыг гаргаж, ҮЦТТХТ-ийн бүртгэх өдрөөр ирүүлсэн жагсаалттай тулгаснаар компанийн нийт хувьцааны бүртгэлд орсон /шилжилт хөдөлгөөн/ өөрчлөлт болон компаниас ХЭ-дэд төлөх төлбөр /бутархай үлдэгдлийг худалдан авсан/ тооцооны нэгдсэн тайлангийн дүнг гарган баталгаажуулж, Хөрөнгийн бирж, ҮЦТТХТ ХХК-д хүргүүлнэ.
- 4.13 ХБирж, ҮЦТТХТ нь дээрхи тайланг хянан, шалгаж зөвшөөрснөөр тус тайланд үндэслэн “Зоос гоёл” ХК-ийн ХЭ-дэд болон Компанид үлдэх шинэчлэгдсэн хувьцааны гүйлгээ /шилжилт хөдөлгөөн/-г нэг удаагийн биржийн гаднах арилжаагаар хийгдсэнээр Компани ҮЦТТХТ-тэй үлдэгдэл төлбөрийг тооцоог хийж дуусгана.
- 4.14 Энэхүү нэг удаагийн арилжааны дараа буюу төсөл хэрэгжиж дууссанаар таны ҮЦТТХТ /БДК/-ийн дансанд хөрвүүлэлтийн үр дүнгээрх бүхэл хувьцаа /бутархай үлдэгдэл дээрээ нэгтгэсэн дүнд хүргэхэд шаардлагатай хувьцааг нэмж худалдан авах эрхээ хэрэгжүүлсэн ХЭ-дийн хувьд 1 ширхэг бүхэл хувьцаа нэмэгдэнэ/, мөн нэгтгэсэн дүнд хүрээгүй үлдсэн бутархай хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгө /нэгж хувьцааг 720 төгрөгөөр тооцсон/ үлдэнэ.

Жишээлбэл:

- Та тус компанийн 50 ширхэг хувьцаатай байсан гэвэл таны хувьцаа нэгтгэсэн дүн болох 288 ширхэгт хүрэхгүй, мөн 55 ширхэгээс доош байх тул танд компаниас хувьцаа нэмж худалдан авах эрх үүсэхгүй. Харин таны бутархай 50 ширхэг хувьцааг компани хүлээх үүргийнхээ дагуу худалдан авч /50*720төг/ 36,000 төгрөгийг төслийн зарласан хугацаа дуусмагц таны ҮЦТТХТ-ийн дансанд байршуулна.
- Та тус компанийн 100 ширхэг хувьцаатай байсан гэвэл таны хувьцаа нэгтгэсэн дүн болох 288 ширхэг бүхэл хувьцаанд хүрэхгүй боловч танд үлдэх бутархай хувьцаа 55 ширхэгээс дээш байх тул нэгтгэсэн дүнд хүргэхэд шаардлагатай 188 ширхэг хувьцааг (288-100) нэмж худалдан авах эрх үүссэн болно. Энэ эрхээ хэрэгжүүлэхийн тулд та зарласан хугацааны дотор энэ төслийн 4.3-д заасны дагуу Хүсэлт гарган, Компанийн дансанд (188ш*720төг) 135,360 төгрөгийг тушааж баталгаажуулсан байна. Хүсэлт гаргаагүй тохиолдолд таны бутархай 100 ширхэг хувьцааг компани хүлээх үүргийнхээ дагуу худалдан авч

- /100*720төг/ 72,000 төгрөгийг төслийн зарласан хугацаа дуусмагц таны ҮЦТТХТ-ийн дансанд байршуулна.*
- *Та тус компанийн 350 ширхэг хувьцаатай байсан гэвэл түүнийгээ 288-д хуваахад $(350:288=1.215)$ 1 бүхэл шинэ хувьцаа ногдож бүхэлд хүрээгүй $(350-288*1=62)$ 62 ширхэг бутархай хувьцаа үлдэж байна. Танд үлдэх бутархай хувьцаа 55 ширхэгээс дээш байх тул, нэгтгэсэн дүнд хүргэхэд шаардлагатай 226 ширхэг хувьцааг $(288-62)$ нэмж худалдан авах эрх үүссэн болно. Энэ эрхээ хэрэгжүүлэхийн тулд та зарласан хугацааны дотор энэ төслийн 4.3-д заасны дагуу Хүсэлт гарган, Компанийн дансанд $(226ш*720төг)$ 162,720 төгрөгийг тушааж баталгаажуулсан байна. Хүсэлт гаргаагүй тохиолдолд таны бутархай 62 ширхэг хувьцааг компани хүлээх үүргийнхээ дагуу худалдан авч $/62*720төг/ 44,640$ төгрөгийг төслийн зарласан хугацаа дуусмагц таны ҮЦТТХТ-ийн дансанд байршуулна.*
- 4.15 Хүсэлт гаргаж буй хувьцаа эзэмшигч компанийн дансанд нэмж худалдан авах хувьцааны төлбөр тушаахдаа дараах зүйлсийг анхаараах шаардлагатай.
- 4.15.1 Компани /Төсөл хэрэгжүүлэх комисс/-аас өөрийн эзэмшиж буй хувьцааны болон худалдан авах эрхтэй хувьцааны тоо /нэгтгэсэн дүнд хүргэхэд шаардлагатай/ ширхэг, төлвөл зохих төлбөр хэмжээ, дансны мэдээллийг асууж тодруулах,
- 4.15.2 Уг төлбөрийг бэлнээр дансанд тушаах болон шилжүүлэхдээ “Зоос Гоёл” ХК-ийн данс мөн эсэхийг сайтар магадлах,
- 4.15.3 Банкны гүйлгээний баримтын утга, зориулалт дээр ХЭ-ийн мэдээлэл /нэр,регистр, утасны дугаар/-ийг заавал тусгах /баримтаа хадгалах/,
- 4.15.4 Хувьцааны болон үнийн мэдээллийг буруу тооцоолсноос хийсэн төлбөрийн хэмжээ эрхээ хэрэгжүүлэхэд төлөх төлбөрийн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд эрх цуцлагдах болохыг анхаарах.
- 4.16 Хүсэлтээ зарласан хугацаанд амжиж компанид ирүүлээгүй, ирүүлсэн ч таны мэдээдэл зөрүүтэй, тушаасан мөнгө төлвөл зохих төлбөрийн хэмжээнд хүрээгүй зэрэг шалтгаануудын улмаас эрх хүчингүй болсон тохиолдолд таны дансанд тушаасан төлбөрийг төсөл хэрэгжсэний дараа баримтыг үндэслэн буцаан олгоно.
- 4.17 Хувьцаа нэмж худалдан авах эрхийг зөвхөн тухайн ХЭ эдлэх бөгөөд бусдад эрхээ шилжүүлэх буюу худалдахыг хориглоно.

ТАВ. Хувьцааг нэгтгэж дуусах

- 5.1 Төсөл бүрэн хэрэгжсэнээр комисс тайлангаа Хөрөнгийн бирж болон Санхүүгийн Зохицуулах Хороонд тайлагнаж, үнэт цаасны бүрдүүлбэр /хувьцаа эзэмшигчдийн болон компанийн эзэмших хувьцааны бүртгэл/-г орсон өөрчлөлтийг ҮЦТТХТ-д хүргүүлж, харин компанийн дүрмийн өөрчлөлтийг улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлэн бүртгүүлснээр компанийн хувьцааг нэгтгэж дууссанд тооцно.

ЗООС ГОЁЛ ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



“ЗООС ГОЁЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС I ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 08 дугаар сарын 24-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

“Компанийн хувьцааг нэгтгэх болон хуваах тухай” Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.6-д заасан Компанийн хувьцааг нэгтгэхэд компанийн гаргасан тухайн төрлийн хувьцааны тоонд орсон өөрчлөлтийг компанийн дүрэмд тусгаж, энэ тухай бүртгэх байгууллагад мэдэгдэх гэсэн заалтыг удирдлага болгон, “Зоос Гоёл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2013 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит бус 1-р хурлын Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн хувьцааг нэгтгэсэнтэй холбогдуулан Компанийн дүрмийн “Компанийн хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгө” гэсэн 4-р бүлгийн

- 4.1.1-д заасан “Компанийн гаргасан хувьцаа нь нэг бүрийн 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 3,754,944 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ” гэж заасныг,

“Компанийн гаргасан хувьцаа нь нэг бүрийн 28,800 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 13,038 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ” гэснээр,

- 4.1.2 -д заасан “...Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 3,754,944 ширхэг энгийн хувьцаа байна” гэж заасныг,

“Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн 28,800 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 13,038 ширхэг энгийн хувьцаа байна”

гэснээр тус тус өөрчөлт оруулсугай.

2. Дүрэмд орсон өөрчлөлтийг Хорооноос Үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн шийдвэр гарсан тохиолдолд УБЕГ-ын харьяа Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэхийг ТУЗ-д даалгасугай.



ХУРЛЫН ДАРГА

М. Билэгт

Ж. БИЛЭГТ